

## 6

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ****Ц.Сарантуяа**

Дэлхий дахин глобалчлагдаж буй энэ эрин үед дэлхий дахинд аялал жуулчлалын салбар илүү эрчимтэй хөгжиж байгаа билээ. Энэ нь ч манай улсад Аялал жуулчлалын салбар хөгжихөд таатай боломжийг олгож байгаа юм. Тэгэхээр манай аялал жуулчлалын салбарт ажиллаж буй энэ бизнесийг эрхэлж буй пүс компаниуд маань зөвхөн өөр хоорондоо өрсөлдөх биш дэлхийн аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөж байгаа гэдгээ ойлгож энэ асар их туршлагатай, хүчин чадал сайтай өрсөлдөгчидтэй зэрэгцэн маш их мэдээлэлтэй, зөв сонголт хийж чаддаг хэрэглэгчдэд үйлчилэхийн тулд мэргэжлийн ул суурьтай судалгаа тооцоон дээр үндэслэн ажиллах хэрэгтэй юм.

**"Аялал жуулчлал бол өөртөө маш олон үйлчилгээний нэр төрлийг багтаасан нийлмэл цогц систем юм".** Иймээс зөвхөн жуулчны баазын үйлчилгээний талаар биш аялал жуулчлалын системд хамаарах бүхий л үйлчилгээний нэр төрөл ангиллийг тодорхойлж, энэ ангилал нэр төрөл тус бүрийн хувьд өнөөдөр ямар байдалтай байгааг тоймлон авч үзлээ.

- Мэдээлэл, зуучлал, зохицуулалтын үйлчилгээ
- Аялал, зугаа цэнгээний үйлчилгээ
- Тээврийн үйлчилгээ
- Байрлуулах салбарын үйлчилгээ
- Хоолны үйлчилгээ
- Бусад үйлчилгээ гэсэн аялал жуулчлалд хамаарах үйлчилгээний үндсэн нэр төрлийн хувьд судалгаа хийж дүгнэлт гаргалаа.
- Мэдээлэл, зуучлал, зохицуулалтын үйлчилгээ.

Манай улсын Аялал жуулчлалын үйлчилгээний салбарын мэдээлэл, зуучлал, зохицуулалтын үйлчилгээг албан ёсоор бүртгэгдсэн 500 гаруй Тур-оператор, Тур-агентууд, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Аялал Жуулчлалын Газар, Төрийн бус

байгууллага болох МАЖХ, Visit Mongolia-2003 YX, зэрэг томоохон байгууллага эрхлэн гүйцэтгэж байсан. Өнгөрсөн жилээс Зам Тээвэр Аялал Жуулчлалын Яам байгуулагдан ажиллаж байна. Монгол улсын Аялал жуулчлалын тухай хуулинд Тур-Агент, Тур-Операторыг Аялал жуулчлалын байгууллага гэж нэрлээд энэ байгууллагын хийх үйл-

ажиллагаа, ангилал, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бүрэн эрхийн талаар хуульчлан зааж өгсөн. Гэхдээ энэ салбарт аялал жуулчлалын тогтвортой идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 100-аад аж ахуйн нэгж байгаа юм. Тур-агент нь үйлчлүүлэгчид, жуулчидтай шууд харьцаж ажилладаг учраас жуулчид аялах газраа сонгох, үйлчилгээний захиалга өгөхдөө тэдэнд илүү найддаг. Манайд одоо Тур-агентын үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас гадна бие даасан хүмүүс энэ үйл ажиллагааг эрхэлж байгаа тал байна.

Гэхдээ одоо Интернэтийн сүлжээг ашиглан аялал жуулчлалын талаар лавлагаа мэдээлэл авах, тухайлбал: аялах орныхоо тухай, тээврийн хэрэгсэл, зочид буудлын захиалга өгөх зэрэг нь барууны орнуудад ердийн зүйл болжээ. Жишээ нь дэлхийд алдартай зочид буудлуудын сүлжээ болох Мариот Интернэшнл, Хилтон хоутелз корпорэйшн, Ай Ти Ти Шератон зэрэг нь өөрсдийн бүхий л үйл ажиллагаандaa интернэтийг ашиглаж байна. Жуулчин тухайн зочид буудалд урьдчилсан захиалга өгөөд захиалга хүлээн авсан тухай баталгааг 20-30 секундын дараа авч байна. Интернэтээр галт тэрэг, онгоцны тийз худалдаалах үйлчилгээ 1997 онд 800 сая амдолларын эргэлттэй байсан бол 2002 онд 8,9 тэрбум амдолларт хүрсэн байна. Аялал жуулчлалын үйлчилгээг интернэтээр худалдах нь Тур-агентуудад хүнд цохилт болж байгаа бөгөөд Англи, Герман зэрэг орнуудад аялал жуулчлалын бизнес томоохон өөрчлөлтийн үе шатанд тулж ирээд байгаа юм. Английн маркетингийн салбарын нэр хүндтэй экспертууд аялал жуулчлалд интернэтийн нөлөө өсч, Тур-агентуудын үүрэг роль багасна гэж тодорхойлжээ. Гэхдээ аялал жуулчлалын эрэлт хэрэгцээнд гарсан сүүлийн үеийн өөрчлөлтийн зуучлагчдын талд ашигтай зарим нэг хандлага байгаа нь зочид, жуулчид аялал жуулчлалын үйлчилгээний талаар ихээхэн мэдээлэлтэй боловч худалдан авах шатанд зөвлөгөө авах хэрэгтэй байдаг байна. Ийм нөхцөлд Тур-агент нь үйлчлүүлэгчдэд өөрсдийн хуримтлуулсан мэдлэг, туршлагад үндэслэн зөвлөгөө өгөх замаар эксперт болон хувирч байна. Үүнээс өмнө тур-агент нь үйлчлүүлэгчдэд зөвхөн тийз урьдчилан захиалах, худалдах зэрэг үйлчилгээ үзүүлдэг байсан бол сүүлийн үед өргөн хүрээтэй үйлчилгээ эрхлэх болж байна. Манай нөхцөлд морь, тэмээ унах, ууланд авирах, ан гөрөө хийх, цэцэг шувуу судлах, эрвээхэй цуглуулах, хадны сүг зураг үзэж сонирхох зэрэг аялалд мэргэжлийн зөвлөгөө өгч болох юм. Тур-операторын үндсэн үйл ажиллагаа нь зах зээлд эрэлт хэрэгцээтэй, борлуулалт сайтай байх аялал жуулчлалын үйлчилгээг судлан боловсруулж зах зээлд гаргах явдал юм.

**Одоогийн байдлаар манай улсад Жуулчин корпораци, Цолмон travel, Nomads, Nomadic expedition, Nature tour гэх мэт томоохон Тур-операторууд ажиллаж байна. ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Аялал Жуулчлалын Газар төр засгийн аялал жуулчлалын талаархи бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж**

байсан. Одоо ЗТАЖ-ын Яам байгуулагдан ажиллаж байна. Монголын Аялал Жуулчлалын Холбоо нь 1992 онд байгуулагдсан, одоогоор хамгийн шилдэг гэсэн 70 гаруй байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн төрийн бус байгууллага юм. Монголын аялал жуулчлалын үйл ажиллагааны чанар байдлыг сайжруулах, шилдэг үйл ажиллагаа дадлага туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилготой ажиллаж байна.

"Visit Mongolia-2003" ҮХ 2003 оныг "Монголд зочлох жил" болгосонтой уялдан тодорхой үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажилласан. Энэ хугацаанд Азийн ханиад буюу Sars гарсан нь манайд зочлох жуулчдын тоонд сөрөгөөр нөлөөлж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй зарим төлөвлөсөн ажлууд сайн хийгдэж чадаагүйтэй уялдан зарим мэргэжилтэн хүмүүс Зочлох жилийг 2004, 2005 онд үргэлжлүүлэх санал гарган Засгийн газарт оруулснаар Discovery Mongolia уриан дор ажилласан. 2006 онд Их Эзэн Чингис хааны Тулгар Төр байгуулагдсаны 800 жилийн ой тохиохтой холбогдуулан Засгийн газраас "Great Mongol- 800" уриан дор Аялал жуулчлалын үйл ажиллагааг өргөн хүрээтэй зохион байгуулахаар хөтөлбөр төлөвлөгөө гаргаад байгаа юм.

Эдгээр байгууллагууд өнөөдөр Монгол улсын аялал жуулчлалын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж байгаа билээ. Ингээд манай оронд зочилж буй гадаадын гийчдийн аялалын зохион байгуулалт ямар байгааг авч үзье.

Аялалын зохион байгуулалт зах зээлийн сегментүүдээр (%)

| Зохион байгуулалт           | Япон                  | Солонгос | Хойд Америк | Австрали | Англи | Герман | Франц | Баруун Европын бусад орнууд | Бусад бүх орнууд | Бүгд |     |
|-----------------------------|-----------------------|----------|-------------|----------|-------|--------|-------|-----------------------------|------------------|------|-----|
| Багц аялал                  | 45                    | 44       | 31          | 20       | 45    | 45     | 50    | 38                          | 16               | 37   |     |
| Өөрийн зохион байгуулалттай | Урьд чилсан төлбөргүй | 43       | 48          | 61       | 69    | 46     | 48    | 47                          | 53               | 72   | 54  |
|                             | Урьдчилсан төлбөртэй  | 12       | 8           | 8        | 11    | 9      | 7     | 3                           | 9                | 12   | 9   |
| Нийт                        |                       | 100      | 100         | 100      | 100   | 100    | 100   | 100                         | 100              | 100  | 100 |

Нийт гийчдийн аялалын зохион байгуулалтыг авч үзвэл 63% нь өөрийн зохион байгуулалтаар аялж байна. Мөн урьдчилсан төлбөргүйгээр

тухайн үед нь төлбөрөө хийх байдлаар аялал зохион байгуулагдаж байгаа байдал их хувь хэмжээг эзэлж байгаа нь анхаарал татсан асуудал юм.

**Аялал, зугаа цэнгээний үйлчилгээ**

Монгол улсын аялал, зугаа цэнгээний үйлчилгээг дараах төрлүүдэд ангилж авч үзлээ.

- Байгалийн үзэсгэлэнт газрын аялал
- Нүүдлийн соёл иргэншилтэй танилцах аялал
- Түүх соёлын дурсгалт зүйлүүдтэй танилцах аялал
- Тусгай сонирхлын болон Адал явдалт аялал
- Бизнес аялал
- Экологийн аялал
- Амралт сувиллын аялал

Эдгээр аялалын төрөл тус бүрээр сонирхлын цэгүүдийг тодорхойлбол: Байгалийн үзэсгэлэнт газрын аялал Говь цөл, Тал хээр, Ёлын ам, Дуут элс, Баянзаг, Хөвсгөл нуур, Монгол Алтай, Горхи Тэрэлж, Хан Хэntийн дархан цаазат газар, Их Говийн дархан цаазат газар, Орхоны улаан цутгалан, Мөнх хөх тэнгэр, Өгий нуур, Элсэн тасархай, Хустайн нуруу, Нүүдлийн соёл иргэншилтэй танилцах аялал Үнээ мал сах, Цагаан идээ боловсруулах, Мал сүргээ хариулахmallах, Ширдэг ширэх, Нүүж буух, Малчин айлд зочлох, Морь тэмээ унах,

Түүх соёлын дурсгалт зүйлүүдтэй танилцах Ардын болон уртын дуу, Морин хуур, Язгуур урлаг, Улгэр домог сонсох, Сүм хийд музей үзэх, Занабазарын гайхамшигт бүтээл, Чингис хааны судлагдахуун, Хар хорин Эрдэнэ зуу, Амарбаясгалант, Манзшир, Мэгжиджанрайсаг, Төвхөн хийд, Хадны сүт зураг бичээс, Хөшөө дурсгал

**Тусгай сонирхлын болон Адал явдалт аялал Ангийн аялал, Загасчлал, Ууланд гарах, Жипийн аялал, Морин болон тэмээн аялал, Морин тэргээр аялах, Хаданд авирах, Монгол үндэсний нум сум харвах, Жимс цэцэг түүх, Шувуу эрвээхэй судлах, Од харах, Явган аялал, Дугуйн аялал, Агуйн аялал, Хоолны баяр хийх, Дэлгүүр, Наадам, Цагаан сар, спортын тэмцээн, Урлагийн тогтолт,**

**Бизнес аялал** Айлчлал, Хурал зөвлөгөөн, Танилцах сурталчилгааны аялал, Конгресс аялал Экологийн аялал Экологийн семинар, Олон нийтийг хамарсан ухуулга сурталчилгаа, Байгалийн онгон, дархан, цогцолборт газраар аялах, хайрлан хамгаалах,

**Амралт сувиллын аялал Рашаан сувиллын газрууд (Шаргалжуут, Жанчивлан, Хужирт, „) Амралтын газрууд**

Манай улсын аялалын гол зорилтот цэгүүд бол Улаанбаатар хот, Говь (31%), Хар Хорин (31%), Тэрэлж (23%), Хөвсгөл (13%) юм.

Аялал жуулчлалын компаниудын аялалын хөтөлбөр нь ерөнхийдөө адил төстэй нэгэн төрлийн, жуулчид сонголт хийх боломжгүй байгаа нь

харагддаг. Үүнд манай орон аялалын үзмэр маш цөөн хоорондоо маш хол байрласан байдаг бэрхшээлтэй асуудлууд нөлөөлж байгаа юм.

### Тээврийн үйлчилгээ

Тээврийн хэрэгсэл нь нэг талаас жуулчдыг шилжүүлэн байрлуулах, зөөвөрлөх хэрэгсэл болдгоос гадна өөрөө аялалын нэг төрөл болж явдаг.

Манай АЖ-ын салбарын үйл ажиллагаанд хамгийн гол бэрхшээлийг үзүүлж байгаа нь тээврийн тэр дундаа агаарын тээвэр буюу онгоцны хүрэлцээ муу гэсэн асуудал юм. МИАТ гэхэд л гадаадад нисдэг 2 дотоодод нисдэг ганц онгоцтой байгаа нь нэмж ганц хоёр онгоц авлаач жуулчдын тоог огцом өсгөх боломжгүй байгаа юм. Харин Аеро

Монголиа компани оны эцсээр Канад улсаас тийрэлтээ Фокер-100 онгоцыг 5 жилийн хугацаатай түрээсээр аваад байна.

Манай орны хувьд авто тээврийг аялал жуулчлалд өргөн ашиглаж байна. Энэ нь манай улс агаарын тээврийн сүлжээ багатай, дийлэнх үзмэрүүд нь хол байрлалтай автомашинаар очихоос өөр боломжгүй зэрэгтэй холбоотой юм. Манай орны дэд бүтэц муу хөгжсөн, шороон зам нь бартаа ихтэй, байгаль цаг уурын өөрчлөлт ихтэй зэрэг нь тээврийн үйлчилгээнд олон бэрхшээлийг бий болгодог. Харин төр засгаас хэрэгжүүлж буй Мянганы зам төсөл амжилттай хэрэгжиж дуусвал тээврийн үйлчилгээнд зохих боломжийг бий болгох юм.

Нөгөөтэйгүүр, Улаанбаатар хотын замын ачаалал маш их байдаг, мөн тээврийн үйлчилгээнд оролцож буй такси, фургон, микро автобус, УАЗ-469, автобус зэрэг тээврийн хэрэгсэл нь үйлчилгээний шаардлагыг тэр бүрий хангахгүй байгаа юм. Харин энэ үйлчилгээнд гарч буй зарим нэг сайн талаас дурдвал, Central asian net Co.,Ltd компани 2002 оноос аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа пүүс компаниудад өнгө үзэмжтэй, найдвартай, засвар үйлчилгээг сайтар хангасан, замын хөдөлгөөний аюулгүй байдлын стандарт бүхий тээврийн хэрэгсэл, дадлага туршлагатай жолоочийн түрээсийн үйлчилгээг үзүүлж байна. Энэ үйлчилгээнд Land Cruiser, Delica, UAZ 469, Mercedes-Benz, Hyundai Microbus гэх мэтийн автомашинууд ашиглагдаж байна. Манай орны хувьд төмөр замын тээвэр тийм ч сайн хөгжиж чадаагүй. ОХУ, БНХАУ 2-ыг холбосон манай орноор дайран онгерөх Сүхбаатар, Замын-Үүдийн чиглэлийн төмөр зам манай орны хувьд төмөр замын аялалын гол түшиц нь болж байна. Монголын төмөр замаар жуулчид ихэвчлэн Бээжин-Москвагийн олон улсын чиглэлээр ирдэг. Монголын Төмөр Замын дэргэд ТЗ-ын АЖТовчоо байгуулагдсанаар галт тэргээр жуулчин тээвэрлэх үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулж байна. Мөн ТЗАЖТ урьд өмнө нь гадаад, дотоодын төр засгийн өндөрлөгүүдэд үйлчлэх зориулалтаар ашиглаж байсан тусгай тоноглолтой вагоныг аялал жуулчлалын зориулалтаар

ашиглаж байна. Одоо Хөвсгөл далайд явж байгаа Сүхбаатар онгоц нь 1985 оноос эхэлж аялж эхэлсэн бөгөөд 800 морины хүчтэй дизель хөдөлгүүртэй, 18000 тн ачаа чирэх хүчин чадалтай, цагт 20-22 км хурдтай хөлөг юм. Гэхдээ энэ онгоц нь ачаа тээврийн зориулалттай зүтгүүр онгоц тул усан аяллын зориулалтаар ашиглахад өртөг их гардаг. Гэхдээ дотоодын жуулчдын сонирхлыг их татдаг.

- Байрлуулах салбарын үйлчилгээ
- Аялал жуулчлалын салбарт Байрлуулах үйлчилгээний дараах төрлүүд байдаг.
- Зочид буудал -Hotels, Motels, Resorts
- Амралт сувиллын газар-Holiday centers/villages
- Жуулчны бааз-Tourist camps
- Дэн буудал-Guest houses
- Аяны отог-Camping & Caravanning
- Түрээсийн орон сууц-Time shite homes/apartments
- Айлд байрлах-Gites/farm accommodation
- Майхан-
- Вагон-Train accommodation
- **Аяллын машин-**

Манай оронд одоогоор Зочид буудал, Жуулчны бааз, Амралтын газар, Сувиллын газар гэсэн байрлуулах үйлчилгээний төрлүүд байна. Ресорт, Мотелийн тухай ойлголт бүрхэг байгаа ч цаашдаа бий болох хандлага байна. Тухайлбал, орчин үеийн шаардлага хангахгүй ч Зочид буудлын шаардлагад нийцэх байгалийн үзэсгэлэнт газруудад байрладаг газруудыг Ресортод хамааруулж болох юм. Сүүлийн үед авто зам дагасан хоолны үйлчилгээний газрууд олноор байгуулагдаж байгаа нь ирээдүйн Мотелийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой юм. Сүүлийн үед бадарчин жуулчид ихээр ирэх болсонтой холбогдон юм. Сүүлийн үед буудлууд олноор бий болж хөгжих байна. Дэн буудлыг Дэн буудлууд олноор байгуулахад их хөрөнгө оруулалт шаарддаггүй, мэргэжлийн боловсон хүчин, мэргэжлийн үйлчилгээ шаарддаггүй нь Дэн буудал хөгжих үндэс болж байна.

Мөн Монголын малчин айлд зочилж, тэдэнтэй хамт нэг гэрт амьдарч үзэх сонирхолтой жуулчдын тоо өсөж байна. Аялал жуулчлал өндөр хөгжихийн хэрээр галт тэрэг ч жуулчдын тав тухтай, тохилог байдлыг хангах зорилгоор аялал жуулчлалын тоноглосон галт тэргүүдийг ашиглаж байна. Жуулчны баазууд нь жуулчдыг хүлээн авах, байрлуулах, хооллох, ахуйн үйлчилгээ үзүүлэх, тоглож наадах зориулалттай өрөө тасалгаа, талбайтай цогц үйлчилгээ үзүүлдэг. Жуулчны баазын үйлчилгээ нь хот суурингийн Зочид буудлаас доогуур түвшинд байдаг хэдий ч энэ ялгаа бага багаар арилах хандлагатай байна. Манай дийлэнх Жуулчны баазууд нь Монгол гэрт байрлуулдгаараа бусад орны жуулчны баазуудаас ялгаатай.

#### ❖ Хоолны үйлчилгээ

Тодорхой нэр төрлийн хоолны үйлчилгээг хүссэн жуулчид, хэрвээ байрлаж байгаа газарт нь тэр үйлчилгээ байхгүй тохиолдолд гадуур хооллох нь их байдаг. Одоогоор Улаанбаатар хотод орчин үеийн том, жижиг 100-аад Зочид буудал, 1000 гаруй Зоогийн газар, Кафе, Бар, Клубтэй байгаагийн дотор гадаадын улс үндэстний хоолтой Зоогийн газар бараг 100 шахам байна. Судлаачдын тогтоосноор Монгол үндэстний уламжлалт хоолны нэр төрөл 350 орчим байдаг ч эдгээрийн дийлэнх нь гол төлөв чанах аргаар боловсруулсан тураг болон дотор махан хоол, сүү, цагаан идээ, боов боорцог байдаг нь гадаадын хүмүүсийн хувьд тэр бүр тохиромж муутай. Гэхдээ Жуулчин компаний Өгөөдэй, Баянгол Зочид буудлын Монголын нэг өдөр гэх мэтийн ресторанууд хоол үйлчилгээгээрээ өндөр түвшинд үйлчилж байгаа юм. Жуулчид Монголчуудын хоолыг махаар төсөөлдөг тул олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн barbecue гэх мэтийн махан хоолыг манайхан сайн хийж сурх нь энэ салбарын үйлчилгээнд гарч буй нэг дэвшил болох юм.

#### ❖ Бусад үйлчилгээ

Дээр авч үзсэн Аялал жуулчлалын үндсэн үйлчилгээнүүдээс гадна аялалын хөтөлбөрт орлоггүй ч жуулчдад үйлчилдэг дараах үйлчилгээнүүдийн талааг авч үзэх нь зүйтэй юм.

**Банк, санхүүгийн үйлчилгээ /American Express & Thomas Cook Travellers чекүүдийг ам доллараар манай томоохон банкууд хүлээн авдаг. VISA ATM машиныг цөөн газрууд үйлчилгээндээ нэвтрүүлээд байна. Зөвшөөрөгдсөн валют солих цэгүүд Цэцэг төв, Ард кинотеатр, ХХБ, Анод, Голомт, Капитрон, Эрэл гм банкууд байна./**

**Даатгалын үйлчилгээ /Манай улсын даатгалын үйлчилгээний байдал гадаад орнуудын шиг тийм төгс хөгжөөгүй байна. Манай аялал жуулчлалын үйлчилгээнд даатгалын асуудал их чухал. Одоогийн байдлаар жуулчид ядаж эмнэлгийн даатгалтай байх хэрэгтэй гэдэг шаардлага тавигдаж байна./**

**Ураг, спорт, соёлын үйлчилгээ /Энэ талаар ноцтой асуудал бараг байхгүй боломжийн гэж үзэж байна./**

**Эрүүл мэндийн үйлчилгээ /Ялангуяа хөдөө орон нутагт аялаж байх хугацаанд эмнэлгийн тусlamжийг түргэн шуурхай, чанартай авч чадахгүй байгаа явдал элбэг байдаг./**

**Харилцаа холбоо, Мэдээллийн үйлчилгээ /Энэ чиглэлээр дорвитой ахиц өөрчлөлтүүд гарч байна. Ихэнхи аймгууд Интернэтийн сүлжээнд холбогдоо, мөн Мобикомын сүлжээ аймаг орон нутгийг хамаарлаа. Зарим пүс компаниас жуулчдад зориулж хиймэл дагуулын тусlamжтайгаар ямар ч байрлалаас холбогдох боломжтой техник хэрэгсэл үйлчилгээг нэвтрүүлээд байна.**

**Аюулгүй байдлыг хангах, Цагдан сэргийлэх албаны үйлчилгээ /Энэ тал дээр нэлээд алдаа дутагдал гардаг. Жуулчид юмаа хулгайд алдах,**

булаалгах зэрэг асуудлууд мэр сэр гардаг. Цаашдаа анхаарах шаардлагатай асуудлын нэг юм.

ШТС, машин техникийн засвар үйлчилгээ /Энэ үйлчилгээ сүүлийн жилүүдэд нэлээд өргөжиж байгаа. Хaa сайгүй ШТС, Машины сэлбэгийн дэлгүүр, засварын газар байгуулагдсан. Харин үйлчилгээний чанарын хувьд анхаарах зүйлүүд их байгаа./

Дэлгүүрийн үйлчилгээ. /Энд бэлэг дурсгалын гол дэлгүүрүүдийг авч үзэв. УИД-ийн тусгай тасаг, Сүхбаатарын талбайн дэргэдэх бэлэг дурсгалын дэлгүүр, Скай худалдааны төв, Жуулчин компаний Shopping Centre, East Shopping Centre, Нарны титэм худалдааны төв, Elegant дэлгүүр. Сүүлийн үед бэлэг дурсгалын зүйлсийн олдоц сайн болсон ч чанарыг төдийлөн сайн гэж жуулчид үнэлээгүй байсан./

Аялал жуулчлалд хамаарах энэ бүх үйлчилгээний чанар стандартын байдлыг судлахад гадаад орнуудын ижил зэрэглэлийн адил нэр төрлийн үйлчилгээний чанар стандартын түвшинээс ихээхэн доогуур түвшинд ажиллаж байгаа юм. Иймээс энэ салбар үйлчилгээний чанар стандартын талаар дорвитой ахиц өөрчлөлт гаргах асуудал чухлаар тавигдаж байна.